



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Монгол үндэсний ардчилсан
намын хаягийн өөрчлөлтийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Баярмаа, С.Батдэлгэр, Н.Батзориг, Н.Батчимэг, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, С.Соёмбо-Эрдэнэ, П.Соёл-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар

Монгол үндэсний ардчилсан намын даргаас ирүүлсэн “хаягийн болон цахим шуудангийн хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” өргөдлийг шүүгч Д.Батбаатарын илтгэснээр хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол үндэсний ардчилсан намын дарга Б.Цогтгэрэл 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн өргөдөлдөө: “Улсын дээд шүүхийн цахим хуудас дахь улс төрийн намын цэс дэх мэдээллийн санд хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 24/3, 04 тоот, намын цахим хуудас <http://muan.mn>, цахим шуудангийн хаяг: info@muan.mn гэж тусгагдсан, намын байршил Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Сүхбаатарын гудамж, 14 дүгээр байрны 11 дүгээр давхарт шилжсэн, цахим хаяг mndp2006.mn@gmail.com болж өөрчлөгдсөн тул намын хаягийн болон байршлын өөрчлөлтийг бүртгэж өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол үндэсний ардчилсан намын хаягийн өөрчлөлтийг тус намын мэдээлэлд бүртгэж шийдвэрлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т “хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, ...”-ийг хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулахаар, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5-д “намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг”-ийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх баримт бичигт бүрдүүлэхээр тус тус зааснаас үзвэл намын гүйцэтгэх удирдлагын байнга оршин суугаа хаяг, түүний өөрчлөлт нь улс төрийн намын улсын бүртгэл, хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарна.

Монгол үндэсний ардчилсан намын дарга Б.Цогтгэрэлээс ирүүлсэн өргөдөл, түүнд хавсаргасан баримтууд “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 3.4.4. “хуулийн 9.3.5-д заасан хууль ёсны хаягийг намын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа газрын хаягаар засаг захиргааны нэгж тодорхойлсон байвал зохино”, 3.7. “Намын баримт бичгийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхэд энэ журмын хавсралт №2А-д заасан баримт бичгийн бүрдэл хангана”, 3.9. “... намын баримт бичгийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт болон намын ... бүртгэлийг хийлгэх өргөдлийг Улсын дээд шүүхээс баталсан маягтын дагуу гаргаж, намын дарга гарын үсэг зурна” гэж заасантай нийцсэн байна.

Үүнээс гадна тус намын цахим шуудангийн хаягийг бүртгүүлэх хүсэлтийг хамтад нь хангаж шийдвэрлэх боломжтой.

Иймд, Монгол үндэсний ардчилсан намын дарга Б.Цогтгэрэлээс ирүүлсэн “Монгол үндэсний ардчилсан намын хаягийн болон цахим шуудангийн хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” хүсэлтийг хангах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5-д заасныг тус тус баримтлан Монгол үндэсний ардчилсан намын хаягийг “Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Сүхбаатарын гудамж, 14 дүгээр байрны 11 дүгээр давхар” гэж, цахим шуудангийн хаягийг “mndp2006.mn@gmail.com” гэж тус тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөн бүртгэсүгэй.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР